



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 54,700,000.00 (тавин дөрвөн сая долоон зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 22,031,944.38 (хорин хоёр сая гучин нэгэн мянга есөн зуун дөчин дөрвөн төгрөг гучин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002018

төсөл

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 6 дугаар сарын 19 ны өдрийн
288 дугаар тогтоолын хавсралт



"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРААС
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг
1	Соната-8, 05-93 УНУ, КМНЕ241САФА057210 Суудлын автомашин	2014/2016	25000	54,700,000.00	22,031,944.38	32,668,055.62
НИЙТ ДҮН				54,700,000.00	22,031,944.38	32,668,055.62
				(тавин дөрвөн сая долоон зуун мянган)	(хорин хоёр сая гучин нэгэн мянга есөн зуун дөчин дөрвөн төгрөг гучин найман мөнгө)	(гучин хоёр сая зургаан зуун жаран найман мянга тавин таван төгрөг жаран хоёр мөнгө)